



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭГ/902

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул хуулийн төслийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт 13 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд:

“I.ХЭЛЭЛЦСЭН нь:

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг хэлэлцээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16^{1.1}-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.05.29 № 4-2/3193

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ж.МӨНХБАТ ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Жич: Хууль зүйн яамнаас ирүүлсэн зөвшөөрлийг хавсаргав.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

0962



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2017.05.26 № 1-1/2219

танай _____-ны № _____-т


**САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийг үндэслэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.



С.БЯМБАЦОГТ

08 1567
Doc.said a5.2017



**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд удааширч, төсөв, төлбөрийн тэнцэлд алдагдал үүссэн бөгөөд ирэх онуудад бондын эргэн төлөлтүүд хийгдэхээр байна. Гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, уул уурхайн хэт хамаарал, төсвийн сахилга бат, нэгдмэл байдал хангалтгүйгээс төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж, үүнийг дагаад өндөр хүүтэй үнэт цаас гаргах замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлж байсан зэрэг нь Засгийн газрын өрийн хэмжээг огцом нэмэгдүүлж, хүүгийн төлбөрийн дарамтыг өсгөснөөр төсвийн тэнцвэргүй байдлыг бий болгоод байгаа юм.

Үүсээд байгаа төсөв, эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах зорилгоор Улсын Их Хурлаас 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" болон ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан билээ.

Засгийн газар дээрх хуулийн төслүүдийг боловсруулахдаа автомашин эзэмшигчийн жил болгон төлдөг татвар, төлбөрийг нэмэгдүүлэлгүйгээр зөвхөн импортоор орж ирж буй суудлын автомашины нэг удаагийн шинжтэй татвар болох онцгой албан татварыг нэмэгдүүлэх, ингэхдээ татварын хувь хэмжээг автомашины хөдөлгүүрийн багтаамж, үйлдвэрлэсэн оноос хамааруулан нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлөхөөр зохицуулсан бөгөөд энэхүү заалтыг 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан байна.

Онцгой албан татвар төлдөггүй байсан эдгээр автомашинд дээрх хуулийн дагуу 375.000-6.675.000 төгрөгийн татвар ногдохоор болсон нь ялангуяа манай улсад хамгийн их эрэлт хэрэгцээтэй байгаа хос тэжээлт буюу “Пруис” машины хэрэглэгч, борлуулагчдад эдийн засгийн урьдчилан тооцоолоогүй, огцом дарамт болж байгаа талаар иргэд, аж ахуйн нэгжээс гомдол, шүүмжлэл ирүүлж байна.

Түүнчлэн татвар нэмэхээс өмнө захиалсан болон лизингээр авсан “Пруис” автомашины захиалсан, борлуулсан, худалдан авагч нарын дунд үл ойлголцол бий болох, гааль дээр хугацаандаа автомашинаа авч чадахгүй бөөгнөрөл үүсэх зэрэг асуудал үүсч байна.

Иймд иргэд, аж ахуйн нэгжийн санал, хүсэлтийг үндэслэн хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтоох зохицуулалтыг бий болгох зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулах онцгой албан татварын хувь, хэмжээг хуульд заасан онцгой албан татварын 0-50 хувиар Засгийн газар тогтоох заалтыг нэмж тусгахаар, 2 дугаар зүйлд мөн хуулийн 7.2 дахь заалтыг хүчингүй болгохоор, 3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Түүнчлэн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 50 хувийн онцгой албан татвар ногдуулж, уг хуулийн дагуу татвар төлөгчид албан татвар төлсөн байна. Иймд энэхүү хуулийн төслөөр дээр дурдсан автомашинд ногдуулах онцгой албан татварыг Засгийн газар тогтоох боломжтой болох тул 5 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийн төсөл батлагдах хүртэл хугацаанд хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулсан албан татварыг татвар төлөгчид буцаан олгоно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох, нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашины онцгой албан татварын хувь, хэмжээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газар тогтоож, иргэд болон аж ахуйн нэгжид учирч байгаа эдийн засгийн дарамтыг тодорхой хэмжээгээр бууруулна.

2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулсан албан татварыг татвар төлөгчид буцаан олгоход 1 тэрбум орчим төгрөг шаардагдана.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа болно.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

ТАНИЛЦУУЛГА

*Онцгой албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Манай улсад үүсээд байгаа төсөв, эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах зорилгоор Улсын Их Хурлаас 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" болон ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан билээ. Засгийн газар дээрх хуулийн төслүүдийг боловсруулахдаа автомашин эзэмшигчийн жил болгон төлдөг татвар, төлбөрийг нэмэгдүүлэлгүйгээр зөвхөн импортоор орж ирж буй суудлын автомашины нэг удаагийн шинжтэй татвар болох онцгой албан татварыг нэмэгдүүлэх, ингэхдээ татварын хувь хэмжээг автомашины хөдөлгүүрийн багтаамж, үйлдвэрлэсэн оноос хамааруулан нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашиныг онцгой албан татвараас чөлөөлж байсан боловч Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлөхөөр зохицуулсан бөгөөд энэхүү заалтыг 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан байна.

Онцгой албан татвар төлдөггүй байсан эдгээр автомашинд дээрх хуулийн дагуу 375.000-6.675.000 төгрөгийн татвар ногдохоор болсон нь ялангуяа манай улсад хамгийн их эрэлт хэрэгцээтэй байгаа хос тэжээлт буюу "Пруис" машины хэрэглэгч, борлуулагчдад эдийн засгийн урьдчилан тооцоолоогүй, огцом дарамт болж байгаа талаар иргэд, аж ахуйн нэгжээс гомдол, шүүмжлэл ирүүлж байна.

Түүнчлэн татвар нэмэхээс өмнө захиалсан болон лизингээр авсан "Пруис" автомашины захиалсан, борлуулсан, худалдан авагч нарын дунд үл ойлголцол бий болох, гааль дээр хугацаандаа автомашинаа авч чадахгүй бөөгнөрөл үүсэх зэрэг сөрөг үр дагаварууд үүсч байна.

Иймд иргэд, аж ахуйн нэгжийн санал, хүсэлтийг үндэслэн хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашинд ногдуулах онцгой албан татварын хувь, хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Засгийн газар тогтоох зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзлээ.

Хуулийн төслөөр Онцгой албан татварын тухай хуульд хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашинд ногдуулах онцгой албан татварын хувь, хэмжээг хуульд заасан онцгой албан татварын хэмжээний 0-50 хувиар Засгийн газар тогтоох заалтыг нэмж тусгалаа.

Мөн хос тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашинд ногдуулах онцгой албан татварын хувь, хэмжээг Засгийн газар тогтоох болсонтой холбогдуулан Онцгой албан татварын тухай хуулийн 7.2 дахь заалтыг хүчингүй болгохоор тусгасан болно.

Түүнчлэн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 50 хувийн онцгой албан татвар ногдуулж, уг хуулийн дагуу татвар төлөгчид албан татвар төлсөн байна. Иймд энэхүү хуулийн төслөөр дээр дурдсан автомашинд ногдуулах онцгой албан татварыг Засгийн газар тогтоох боломжтой болох тул 5 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийн төсөл батлагдах хүртэл хугацаанд хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулсан албан татварыг татвар төлөгчид буцаан олгохоор Онцгой албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ...дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмсүгэй:

“6.8.Хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 6.3-т заасан онцгой албан татварын хэмжээний 0-50 хувиар Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 7.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ...дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуульд заасны дагуу 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2017 оны ... дугаар сарын ..-ны өдрийг хүртэлх хугацаанд хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулсан онцгой албан татварыг татвар төлөгчид буцаан олгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**“ЭКО АВТОМАШИН
ИМПОРТЛОГЧДЫН ХОЛБОО”
ТББ**

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 17-р хороо
Өнөр хороолол, 32-126 тоот,
Утас: 98116211
e-mail:lkhagva_8606@yahoo.com

2017.05.05 № 1/103
Танай _____ -ын № _____ -г

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН ЯАМНЫ
САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН
ТАНАА

*Төр засгийн
v/w*

*ТБТГ-г
сүүдрийн тэмдэгт
Б.О.О*

Санал, хүсэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 04 сарын 14-ны өдөр төсвийн тодотгол батлахдаа Онцгой албан татварын хуулиар хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинаас онцгой албан татвар авахаар хуульчилсан.

Олон улсын жишгээр Онцгой албан татварыг хувь хүн, нийгэм, хүрээлэн буй орчинд хортой, сөрөг нөлөө үзүүлдэг бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах зорилгоор ногдуулдаг. Гэтэл байгаль орчинд ээлтэй, шатахууны зарцуулалт бага, дундаж буюу дунджаас доогуур орлоготой иргэдийн гол хэрэглээ болсон хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинаас онцгой албан татвар авах болсон нь эдийн засгийн хүндрэлтэй үед татвар нэрийн дор ард иргэдийн нуруун дээр хэмжээлшгүй их дарамт учруулсан туйлын буруу шийдвэр боллоо.

Өнөөгийн улс орны эдийн засгийн хүндрэлийг жирийн иргэд бий болгоогүй. Хямралаас гарахын тулд төр өөрийн үр ашиггүй зардлаа хэмнэх байдлаар гэтлэх арга боломжийг олж харахгүйгээр шууд татвар нэмэх байдлаар жирийн ард иргэдийн нуруун дээр өөрийн алдаатай бодлогын балгыг үүрүүлж байгаа нь харалган төрийн бодлого юм.

Онцгой албан татварийн хуулийн нэмэгдлээс өмнө ихэнхи иргэд автомашин худалдан авахдаа гурав хүртэлх жилийн хугацаатай автомашин лизингийн зээлээр авдаг байсан. Уг хуулийн өөрчлөлтөөс шалтгаалан жирийн ард иргэдийн худалдан авах автомашины үнэ 10-85 хувиар өсөхөөр байна. Энэ нь ард иргэдийн хувьд маш их дарамт болох бөгөөд худалдан авах боломжгүй болно.

Мөн автомашин импортлогч иргэдийн хувьд Япон улс руу тухайн автомашин гааль дээр ирэх хугацаанд /40-50 хоног/ бүх мөнгөө урьдчилж төлдөг. Одоогийн байдлаар автомашин импортлогч иргэдийн худалдан авсан автомашины урьдчилгаа төлбөр болох 6 тэрбум орчим төгрөг шилжүүлэгдсэн байгаа бөгөөд Монгол улсад орж ирэх үед гэнэт хэрэгжиж эхэлсэн хуулийн дагуу захиалсан байгаа автомашинуудад шинэ хуулиар татвар тооцуулан автомашинаа авч чадахгүйд хүрээд байна. Учир нь бид банкны зээл болон өөрийн санхүүгийн чадамжид нийцүүлэн автомашин захиалсан тул тооцоолоогүй асар их санхүүгийн хохиролд ороход хүрч, бидний худалдан авсан автомашинууд Япон улсад үлдэн Монгол руу орж ирэх боломжгүй болоод байна. Энэ

нь 8000 гаруй жирийн иргэдийн орон байр, эд хөрөнгөө барьцаалан авсан зээлийн хөрөнгө юм.

Түүнчлэн Онцгой албан татварын хуулийн бүх төрлийн согтууруулах ундаа импортлогч нарт холбогдох хэсгийг 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс, автомашин импортлогч нарт холбогдох хэсгийг 2017 оны 05 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр тус тус ялгаатай заасан нь Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэг, 14-р зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгүүдийг зөрчиж байна.

2017 оны Төсвийн тодотголын төслийг Сангийн яамнаас боловсруулан УИХ-д өргөн барихдаа автомашины бизнес эрхлэгчдийн санаа бодлыг сонсохгүйгээр хууль батлагдсан өдрөөс хойш хэрэгжиж эхлэх хугацаа хүртэл 15 хоног байхаар тооцоолсон нь өнөөдрийн ийм байдлыг үүсгээд байна.

Рио Тинто хэмээх гадаадын хөрөнгө оруулалттай нэг компанийн эрх ашиг хөндөгдөхөд Сангийн яамнаас УИХ-ын 29 тогтоолд өөрчлөлт оруулахаар төсөл санаачлан шийдвэр гаргуулсан шигээ Монголын жижиг бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж өгнө үү.

Бидний хувьд нэгэнт батлагдсан хууль тогтоомжийн зөв бурууг тогтоохоос илүүтэйгээр 2017 оны 04 сарын 14-ний өдөр батлагдсан “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулах замаар эсхүл уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль гаргах замаар 2017 оны 05 сарын 01-ний өдрөөс өмнө захиалагдсан автомашинуудыг хуучин татвараар оруулж ирэх боломжийг олгож өгөхийг хүсч байна.

Бидний гаргасан энэхүү шаардлагын хариуг 2017 оны 05 сарын 08 дотор өгөхгүй бол тэмцлийн дараагийн хэлбэрт шилжих болно.

ХҮНДЭТГЭСЭН

ТЭРГҮҮН



/Ц.ЛХАГВАЖАВ/

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн Ажлын хэсгийн нэрс

1.Сангийн сайд Б.Чойжилсүрэн

2.Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга

П.Сайнзориг

4.Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга П.Билгүүн

5.Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Алтанзул

6.Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт

7.Сангийн яамны мэргэжилтэн Т.Гэрэлчимэг

8.Гаалийн ерөнхий газрын гаалийн ахлах байцаагч Я.Эрдэнэчимэг